

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны 10 дугаар
сарын 03 -ны өдөр

Дугаар 3661 А/191

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2024 оны 218 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.1.1.18, 2.1.1.21, 2.3.1.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл настан, идэвхтэй насжилтыг дэмжих арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газар (Ю.Отгонбилэг)-т үүрэг болгосугай.

3. "Эрүүл настан, идэвхтэй насжилтыг дэмжих арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөө"-г хэрэгжүүлж ажиллахад аймаг, нийслэл, дүүргийн холбогдох байгууллага, нэгжийн уялдаа, зохион байгууллалтыг хариуцан, биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн, дараа оны 01 дүгээр сарын 30-ны дотор гарган дээд шатны байгууллагад ирүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл), Геронтологийн үндэсний төв (Д.Бат-Ундрах), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (З.Бауыржан) –т тус тус даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Д.Ренчиндорж)-д тус тус даалгасугай.



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Ж.ЧИНБҮРЭН

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД



Т.АУБАКИР

ЭРҮҮЛ НАСТАН, ИДЭВХТЭЙ НАСЖИЛТЫГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025-2028 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрэх үр дүн	Санхүүжүүлэх эх үүсвэр	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
Зорилт 1: ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ НАСЖИЛТЫГ ДЭМЖИХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ									
Үйл ажиллагааны чиглэл 1.1 Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийг боловсронгуй болгох									
1.1.1	Ахмад настанд цогц үнэлгээ хийх зааврыг шинэчлэн боловсруулж батлуулах	ЭМ-ийн сайдын 2024 оны А/22 дугаар тушаал	Шинэчлэн батлагдсан заавар-1	Тоо	Ахмад настанд цогц үнэлгээ хийх заавар батлагдсан байна	Үйл ажиллагааны зардал	2026	ЭМЯ Геронтологийн үндэсний төв	ГБХНХЯ
1.1.2	Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин гэмтлийн жагсаалтыг шинэчлэх	ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын 2021 оны А/807, А/216 дугаар хамтарсан тушаал	Шинэчлэн батлагдсан тушаал-1	Тоо	Тушаал батлагдсан байна	Үйл ажиллагааны зардал	2026	ЭМЯ ГБХНХЯ	ХЗДХЯ Эмч нарын мэргэжлийн зөвлөл
1.1.3	Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах	ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын 2024 оны А/75, А/514 дүгээр хамтарсан тушаал	Шинэчлэн батлагдсан тушаал-1	Тоо	Тушаал батлагдсан байна	Үйл ажиллагааны зардал	2026	ГБХНХЯ	ХЗДХЯ ХХҮЕГ Ахмадын холбоо
1.1.4	"Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй, төлөвлөгөөний жишиг загвар"-ыг шинэчлэн батлах	ХНХС-ын 2020 оны А/121 дүгээр тушаал	Шинэчлэн батлагдсан тушаал-1	Тоо	Тушаал батлагдсан байна	Үйл ажиллагааны зардал	2026	ГБХНХЯ ЭМЯ	ХЗДХЯ ХХҮЕГ Ахмадын холбоо

1.1.5	Ахмад настныг асарч буй асран хамгаалагч гэр бүлд тэтгэмж олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах	Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоол	Батлагдсан журам-1	Тоо	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2026	ГБХНХЯ	ХХҮЕГ
1.1.6	Ахмад настны тусламж, үйлчилгээний эмнэл зүйн зааварыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;	2019, 2022 онд батлагдсан заавар	Шинэчлэн батлагдсан заавар,	Тоо	Заавар, батлагдсан хэрэгжсэн байна.	Улсын төсөв	2026-2028	ЭМЯ-ны холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоо	Геронтологийн үндэсний төв

Үйл ажиллагааны чиглэл 1.2 Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад салбар дундын оролцоог хангах

1.2.1	Насжилтын асуудлаарх үйл ажиллагааны Олон улсын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг ахмад настны оролцоотойгоор гаргах салбар дундын ажлын хэсгийг байгуулан, ажиллах	2020 оны тайлан	Ажлын хэсгийн тушаал Судалгаа Тайлан	Тоо	Ажлын хэсэг байгуулагдсан байна. Судалгаа хийсэн байна. Тайлан үр дүнг гаргасан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2027	ГБХНХЯ ЭМЯ	ЗГ-ын холбогдох байгууллагууд, Монголын ахмадын холбоо, ТББ-ууд Ахмадын төлөөлөл
1.2.2	Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний санхүүжилт, тогтолцооны талаар судалгаа хийх	АХБ-ны ТТ төслийн хүрээнд хийгдсэн судалгаа 2020-2025	Судалгаа Тайлан	Тоо	Судалгаа хийсэн байна.	Олон улсын байгууллагын санхүүжилт	2025-2027	ГБХНХЯ	АХБ
1.2.3	Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламжийн тогтолцоог бий болгох АХБ-ны төслийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах	0	Төлөвлөгөө	Тоо	Төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна.	Олон улсын байгууллагын санхүүжилт	2025-2027	ГБХНХЯ	ЭМЯ АХБ
1.2.4	"Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам"-ын хүрээнд орон нутгийн мэргэжлийн хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллуулах	0	Мэргэжлийн баг Хэрэгжилтийн тайлан	Тоо, Хэрэгжилтийн хувь	Мэргэжлийн баг байгуулагдсан байна. Үйл ажиллагаа тогтмолжсон байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2027	ГБХНХЯ	Аймаг дүүргийн ЗДТГ, холбогдох байгууллага, Монголын ахмадын холбоо, ТББ-ууд

1.2.5	Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээнд ахмад настны эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр туссан арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтийг үнэлэх	2024 онд байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт	2025 онд байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт	Тоо, хувь	Гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжсэн байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2028	Аймаг, дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс	Аймаг, дүүргийн ХХУТГ/хэлтэс/, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Ахмадын байгууллага
1.2.6	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд ахмадын сувиллын үнийн хөнгөлөлт, протез, ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх асуудлыг судлан хуулийн төсөлд тусгах	Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, хэрэгжүүлэх журам	Боловсруулсан хуулийн төсөл	Тоо	Хууль, журмын төсөл	Үйл ажиллагааны зардал	2025-2028	ГБХНХЯ, ЭМЯ	ХЗДХЯ, ХХҮЕГ
1.2.7	Эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэх эмийн хөнгөлөлт, ахмадын сэргээн засах үйлчилгээний хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэх	2024 онд ЭМДСангаас зарцуулсан санхүүжилт	Өмнөх оноос нэмэгдсэн санхүүжилтийн хувь	Хувь	Үйлчилгээний хүртээмж, санхүүжилт нэмэгдсэн байна.	Үйл ажиллагааны зардал	2026-2028	ЭМЯ	ЭМДЕГ
Зорилт 2: АХМАД НАСТАНД ЦОГЦ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ									
Үйл ажиллагааны чиглэл 2.1 Эрүүл мэндийн салбарт урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх									
2.1.1	ЗГҮАХ-2.3.2.8 Эрүүл мэндийн анхан шатлалд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажиглан, халамжийн ажилтнуудыг ахмад настанд цогц үнэлгээ хийх, зөвлөгөө өгөх чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулах	2024 онд 500 гаруй эрүүл мэндийн анхан шатлалд ажиллаж буй эмч, мэргэжилтнүү -дийг сургалтад хамруулсан	2024 оны сургалт	Хүний тоо	Сургалтад 500-аас доошгүй ажиглан хамрагдсан байна.	Улсын төсөв, Эрүүл мэндийг дэмжих сан, Олон улсын байгууллага	2025-2028	ЭМЯ, ГБХНХЯ, ГҮТ, ЭМХТ, ХХҮЕГ	Аймаг, дүүргийн ХХУТГ/хэлтэс/, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

2.1.2	Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний талаар холбогдох талуудад сургалт хэлэлцүүлэг хийх	0	Сургалт хэлэлцүүлэг	Тоо	сургалт хэлэлцүүлэг хийсэн байна.	Олон улсын байгууллага	2025-2026	ГБХНХЯ,	Азийн хөгжлийн банк
2.1.3	Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн халамжийн тусламж үйлчилгээний сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	0	Сургалтын хөтөлбөр /богино хугацааны/ Хэрэгжилт	Тоо	Хөтөлбөр батлагдаж хэрэгжсэн байна.	Улсын төсөв, Эрүүл мэндийг дэмжих сан, Олон улсын байгууллага	2026-2027	ГБХНХЯ	Азийн хөгжлийн банк
2.1.4	Ахмад настанд тусламж үзүүлэх мэргэшсэн эмч, сувилагчийн хомсдлыг арилгах, мэргэжлийн эмч-настан судлал хөтөлбөр хэрэгжүүлэх.	1 жилд, гериатрийн мэргэшсэн эмч 1-3, сувилагч 1-3 ийг бэлтгэдэг	Хөтөлбөр, түүний хэрэгжилт	Тоо	Хөтөлбөр батлагдаж хэрэгжсэн байна.	Улсын төсөв,	2026-2028	ЭМЯ	Эрүүл мэндийн хөгжлийн төв, Геронтологийн үндэсний төв

Үйл ажиллагааны чиглэл 2.2 Нийгмийн халамжийн салбарт ахмад настны цогц тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх

2.2.1	Ахмад настны асаргаа, сувилгааны сургалтын модулыг боловсруулж онлайн хичээлийг платформд байршуулах	0	Сургалтын модуль	Сургалт ын тоо, Хүний тоо	Сургалт зохион байгуулсан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2028	ГБХНХЯ	ЭМЯ, ХХҮЕГ
2.2.2	Орон нутгийн мэргэжлийн хамтарсан байгуулах, гишүүдийг чадаажуулах сургалтад хамруулах	-	Зохион байгуулсан сургалт	Сургалт ын тоо, Хүний тоо	Сургалт зохион байгуулсан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2028	ГБХНХЯ	ХХҮЕГ, Эрүүл мэндийн хөгжлийн төв,
2.2.3	Улс, орон нутаг, хувийн хэвшлийн асрамжийн газрын ажилтнуудад онол, практик хосолсон сургалт зохион байгуулах	2023 оны асрамжийн ажилтнуудын сургалт	Зохион байгуулсан сургалт	Сургалт ын тоо, Хүний тоо	Сургалт зохион байгуулсан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2028	ГБХНХЯ	ХХҮЕГ, Геронтологийн үндэсний төв МУЗН
2.2.4	Орон нутгийн төрийн байгууллагуудад ахмад настны эрх, нийгмийн үйлчилгээг хүргэх чиглэлээр ажилладаг ажилтнуудад эрүүл, идэвхтэй насжилтын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах	0	Зохион байгуулсан сургалт	Сургалт ын тоо, Хүний тоо	Сургалт зохион байгуулсан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2028	ГБХНХЯ, ЭМЯ	ХХҮЕГ, Эрүүл мэндийн хөгжлийн төв

2.2.5	Ахмадын төвүүдийн тоог нэмэгдүүлэх замаар ахмад настны хамрагдалтыг сайжруулах	2025 онд 29 төв	Төвийн тоо	Тоо	Үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2028	ГБХНХЯ	ХХҮЕГ, Эрүүл мэндийн хөгжлийн төв,
Үйл ажиллагааны чиглэл 2.3 Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих болон асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон ТББ-ын хүний нөөц, техникийн чадавхыг бэхжүүлэх									
2.3.1	Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих болон асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшил, ТББ-ын ажилтнуудад чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах	0	Зохион байгуулсан сургалт	Сургалт ын тоо, Хүний тоо	Сургалт зохион байгуулсан байна.	ОУБ-ын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, Үйл ажиллагааны зардал	2025-2028	ГБХНХЯ, ЭМЯ	ХХҮЕГ, Эрүүл мэндийн хөгжлийн төв
2.3.2	Ахмадын эрүүл мэндийг дэмжигч төрийн бус байгууллагуудад эрүүл насжилтыг дэмжих сургалт зохион байгуулах;	0	Сургалтын удирдамж, хөтөлбөр	Сургалт ын тоо, Хүний тоо	Сургалт зохион байгуулсан байна.	Улсын төсөв	2025-2028	ЭМЯ	Геронтологийн үндэсний төв
2.3.3	Ахмад настныг асарч буй гэр бүлд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар мэдээлэл хүргэх уулзалт зохион байгуулах	0	Зохион байгуулсан уулзалт	Уулзалт ын тоо, Хүний тоо	Уулзалт зохион байгуулсан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2026	ГБХНХЯ, ЭМЯ	ХХҮЕГ, Эрүүл мэндийн хөгжлийн төв,
2.3.4	Орон нутагт ХХҮГ-тай гэрээ хийж, үйл ажиллагаа явуулдаг ахмадын төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, идэвхтэй насжилтыг дэмжих төв, асаргааны байгууллагуудын нэгдсэн бүртгэл мэдээлэл үүсгэх	0	2025 онд үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байгууллагын жагсаалт	Шинээр бүрдүүлс эн мэдээлл ийн сан	ХХҮЕГ бүртгэл мэдээллийг үүсгэн, тогтмол шинэчлэлт хийж ажилласан байна.	Үйл ажиллагааны зардал	2025-2028	ХХҮЕГ	Аймаг, дүүргийн ХХҮГ/хэлтэс/
2.3.5	Кейс менежментийн аппликэйшн/г орон нутагт ахмад настны чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад ашиглуулах	АХБ-ны туршилтын төслийн хүрээнд хамрагдсан ахмад настан	Аппликэйшний дагуу үнэлгээ хийгдэж, үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо	Хүний тоо	Жил бүр 300-аас доошгүй ахмад настанд үнэлгээ хийж үйлчилгээнд хамруулсан байна.	Үйл ажиллагааны зардал	2026-2028	ХХҮЕГ	Аймаг, дүүргийн ХХҮГ/хэлтэс/
2.3.6	Улс, орон нутгийн асрамжийн газрууд болон хувийн хэвшлийн		Аппликэйшн-ний дагуу үнэлгээ	Хүний тоо	Улс, орон нутаг, хувийн хэвшлийн		2026-2028	ХХҮЕГ	

	асрамжийн асруулж байгаа иргэдэд Цогц үнэлгээ хийх, Кейс менежментийн аппликэйшнг асрамжийн үйлчилгээнд нэвтрүүлэх	-	хийгдсэн, ахмадын тоо	асрамжийн газрын асруулагчдад үнэлгээ хийгдсэн байна.	Үйл ажиллагааны зардал			Аймаг, дүүргийн ХХҮГ/хэлтэс/, Асрамжийн газрууд
2.3.7	Ахмад настныг хөгжүүлэх, асрах чиглэлээр сайн дурын хөдөлгөөнийг өрнүүлэх	0	Сайн дурын ажилтныг элсүүлэх хөдөлгөөнийг өрнүүлэх	Сайн дурын ажилтнаас үйлчилгээ авсан ахмад настны тоо	Үйл ажиллагааны зардал	2027-2028 онд	ХХҮЕГ	Аймаг, дүүргийн ХХҮГ/хэлтэс/
2.3.8	Ахмад настны идэвхтэй насжилтын төвүүд, асрамжийн газруудад шаардлагатай тоног төхөөрөмж, асаргаа сувилгааны хэрэгслийн дэмжлэг үзүүлэх	-	Тоног төхөөрөмж, хэрэгслийн тоо	Тоног төхөөрөмж, хэрэгслийн тоо	Олон улсын байгууллагын санхүүжилт	2026-2028	ГБХНХЯ	АХБ, Аймаг, дүүргийн ХХҮГ/хэлтэс/

Зорилт 3: Эрүүл, идэвхтэй насжилтын талаарх олон нийтийн ойлголт, мэдээллийг сайжруулах, эрүүл насжилтыг дэмжих технологи, инновацийг хөгжүүлэх

Үйл ажиллагааны чиглэл 3.1 Эрүүл, идэвхтэй насжилтын талаарх олон нийтийн ойлголт, мэдээллийг сайжруулах								
3.1.1	Ахмад настны онцлог хэрэгцээ, эрүүл, идэвхтэй насжилт, асаргаа сувилгахуйн асуудлаар шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдад зориулсан сургалт хийх, оролцогч талуудын “Дугуй ширээний ярилцлага” зохион байгуулах	0	Зохион байгуулсан арга хэмжээ	Арга хэмжээг зохион байгуулж, зөвлөмж, шийвэр гарсан байна.	Улс, орон нутгийн төсөв, Олон улсын байгууллагын санхүүжилт	2026-2028	ЭМЯ, ГБХНХЯ,	Засгийн газрын бусад байгууллага, орон нутгийн Захиргааны байгууллага, Ахмадын байгууллага
3.1.2	Ахмадын насжилтыг идэвхтэй насжилтыг дэмжих төв, асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлдэг байгууллага, асаргаа үзүүлэгч гэр бүлийн сайн туршлагын талаар нэвтрүүлэг, контент бэлтгэн түгээх	0	Бэлтгэсэн нэвтрүүлэг, контент	Нэвтрүүлэг, контентыг олон нийтэд түгээсэн байна.	Улс, орон нутгийн төсөв, Олон улсын байгууллагын санхүүжилт	2026-2028	ЭМЯ, ГБХНХЯ, ХХҮЕГ, Геронтологийн үндэсний төв	Аймаг, дүүргийн ХХҮГ/хэлтэс/
3.1.3	Асрахуйн эдийн засгийн үнэ цэнийг олон нийтэд ойлгуулах нөлөөллийн ажлыг зохион байгуулах	0	Тоо	Нэвтрүүлэг, контентыг олон	Улс, орон нутгийн төсөв,	2026-2028	ЭМЯ, ГБХНХЯ	Аймаг, дүүргийн ХХҮГ/хэлтэс/

[illegible]

Үйл ажиллагааны чиглэл 4.1 Эрүүл, идэвхтэй насжилтын чиглэлээр тандалт судалгаа хийх									
4.1.1	Монгол настны эрүүл мэнд, нийгмийн халамж, эдийн засгийн байдлын талаар үндэсний хэмжээний судалгаа хийх.	0	Судалгааны тайлан	Тоо	Судалгааны үр дүнг танилцуулсан байна.	Улсын төсөв, Олон улсын байгууллагын дэмжлэг	2026-2028	ГБХНХЯ, ЭМЯ	Геронтологийн үндэсний төв, АШУҮИС
4.1.2	Ахмад настны өвчлөл, эрсдэлт хүчин зүйлсийг тандан судлах нэгж байгуулах.	0	Байгуулагдсан нэгжийн бүтэц	Тоо	Нэгж байгуулагдсан байна.	Улсын төсөв	2027-2028	Геронтологийн үндэсний төв	ЭМЯ
Үйл ажиллагааны чиглэл 4.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх									
4.2.1	Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлого, стратеги, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх заавар журам боловсруулах, хэрэгжүүлэх	Заавар, журам-1	Шинэчлэгдсэн заавар, журам	Тоо		Улсын төсөв, Олон улсын байгууллага	2026-2027	ЭМЯ	ГБХНХЯ
4.2.2	Эрүүл мэндийн хөгжлийн төв дэх ахмад настны өвчлөлийн бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох	Өвчлөлийн бүртгэлийг 60 ба 65 наснаас дээш гэж бүртгэж байна.	Шинэчилсэн бүртгэл, мэдээлэл		Шинэчилсэн бүртгэл, мэдээллийг ашиглаж эхэлсэн байна.	Улсын төсөв	2026-2028	ЭМХТ	Геронтологийн үндэсний төв
4.2.3	Ахмад настнуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх		Шалгалтын ажлын удирдамж-2	Тоо	Хууль, тогтоомжийн хэрэгжилт сайжирсан байна.	Улсын төсөв	2026-2028	ГБХНХЯ, ЭМЯ	Эрүүл мэндийн хөгжлийн төв, ХХҮЕГ